



Thomas Jefferson Middle School

IB MYP-ийн есдүгээр сарын

мэдээллийн хуудас

Өөрсдийгөө, ирээдүйгээ, дэлхий ертөнцөө ойлгож сайжруулахын төлөө хамтдаа суралцаж байна.



Энэ сарын шилдэг сурагч: ТЭНЦВЭРТЭЙ

IB-ийн суралцагчдыг бид онол, бие бялдар болон сэтгэл хөдлөлийн хувьд бүх талаар нь **жигд тэнцвэртэй** байлгахыг хүсдэг. Бид хүүхдэд бүх талын боловсрол олгохыг зорьдог. Аль хэдийнээ цөөнгүй сурагч завгүй амьдралаа тэнцвэртэй байлгах гайхалтай чадвараа харуулж байна.



Манай хамгийн шилдэг тэнцвэртэй суралцагчид нь **Dolphins - Bella Deflippi, Dragons - Emma Abramson, Eagles - Zosia Barry, Gators - Cheyenne Klapper, Monarch - Max Thompson, Owl - Hannah Nilame, Penguins - Jason Hernandez, Phoenix - Elaine Chu, and Stingrays - Emory Loughy.**

Эх сурвалж: <https://pixabay.com/en/sunset-mountain-balance-top-1757593/>

Бичгээр гаргасан сургалтын хөтөлбөр

Манай Шинжлэх ухааны ангиуд нь энэ жилээс MYP үнэлгээг APS-ийн дүнгийн удирдамжтай бүрэн нийцүүлэх шинэ зүйл туршиж байна. Бид хэд хэдэн нэгтгэсэн үнэлгээний хүрээнд жилийн үйл ажиллагааг зорилгоос нь эхэлж төлөвлөдөг. Дараа нь нэгж тус бүрийн нэгтгэсэн үнэлгээ(үүд) дээр суурилан хичээлүүдийг зорилгоос нь эхэлж төлөвлөнө.

Шинжлэх ухааны хувьд бүх агуулга, үр чадвар болон үнэлгээг дараах шалгуурт нийцүүлнэ: А-Мэдлэг болон ойлголт, В-Сонирхол болон зохион бүтээх, С-Үйл явц болон үнэлгээ хийх, D-Шинжлэх ухааны нөлөөллийг эргэцүүлэн бодох. Мэдэгдэж байгаа шалгуурт үндэслэн түвшнийг тогтоох нь бүх түвшний хувьд илүү тогтвортой, ил тод, шударга болж чадна гэсэн гол санаа юм.

IB-ийн удирдамжийн талаар тайлбарлавал: Үнэлгээ



Бүх IB-ийн сургууль үр дүнг бүхэлд нь хүлээн авах дөрвөн удирдамжтай байх шаардлагатай: [Хичээлийн шударга байдал](#), [Үнэлгээ](#), [Олон талт байдлын оролцоог хангасан байдал](#) болон [Хэл](#). Өнгөрсөн жил бүх удирдамж хянагдсан буюу дахин бичигдсэн. MYP-ийн хэд хэдэн шаардлагыг хангаж чадахгүй байгаа учир үнэлгээний удирдамж нь одоогоор хамгийн их анхаарал хандуулах хэрэгтэй удирдамж болоод байна.

Иймээс үнэлгээний практикийг жигд, ил тод, шударга байлгах үүднээс шинэ удирдамжийн төсөл боловсруулах ажлыг TJ-ийн ажилтнуудаас бүрдсэн хороо энэ сараас эхлүүлнэ. Энэ үйл явц нь цаг хугацаа шаардах ч бидний үнэлгээний дүн бүгдэд давуу болон тэгш байдал олгохыг бид хүсэж байна.

Эх сурвалж: pixbay.com

MYP-ийн анги, бодит үнэлгээ

Манай тайзны урлагийн 8-р ангийн сурагчид шоу хөтөлбөр хэрхэн хийхийг аль хэдийн сурч мэдсэн! Мэдээж тэд үр чадвараа дээшлүүлэхэд хийх ажил их байгаа ч тэд аль хэдийн бүжиг болон ам барих үзүүлбэртээ бүтээлч, авьяаслаг, тууштай байдлаа харуулсан. Гурван ангилалд таван баг дөрвөөс таван шүүгчийн өмнө өрсөлдсөн. Ихэвчлэн үр дүн нь маш ойрхон байсан. Ангилал тус бүрийг дуусах хүртэл оноог зарлаагүй.



Энэхүү үнэлгээг MYP урлагийн шалгуурыг ашиглан А-Мэдлэг болон ойлголт, С-Бүтээлч сэтгэлгээ зэргээр үнэлсэн болно. Энэ нь бүх сурагчийн хувьд тааламжтай сорилт байсан. Зураг: Ноён. Malinosky.

Олон нийтийн төсөл

Олон нийтийн төсөл буюу манай суурь IB-ийн төсөл нь 8-р ангийн бүх сурагчид зориулан үйл ажиллагаагаа эхлүүлээ. Энэ жил бид сурагчдыг Олон нийтийн төслийн судалгаа, төлөвлөлтийн үе шатыг дуусгахын тулд YJP-д ажиллуулна.



Сурагчид дуусгаахаар сонгосон үйлчилгээг судалж, төлөвлөж, арга хэмжээ авч, танилцуулах болно. Сурагчид анхаарлаа төвлөрүүлэх олон нийтийн зорилтыг аль хэдийн сонгосон байх ёстой. Хамгийн түгээмэл сонгогдсон хэрэгцээ бол цаг уурын өөрчлөлт юм. Бүх нөөц нь 8-р ангийн TA Canvas дээр бий. [Олон нийтийн төслийн](#) талаар илүү ихийг эндээс үзнэ үү.

Эх сурвалж: pixbay.com

Дэлхий даяарх үйл явдал

Жефферсоны сурагчид Дориан хар салхины улмаас сүйдсэн Бахамын арлуудад туслах ажил өрнүүлж байна. SCA-ийн ивээн тэтгэсэн үдийн хоолны үеэр бид Бахамын арлуудад туслах хандив хүсэж байна. Баруун талд байгаа сурталчилгааны хуудсыг манай сурагчдын нэг болох Ayodeji Obikoya зохиосон. Бүх цуглуулсан мөнгөө Бахамын арлуудын Улаан загалмайн нийгэмлэгт хандивлах болно.



Түүнчлэн Бахамын арлуудаас ирсэн манай хэд хэдэн сурагч Олон Нийтийн Төслөө дээрх арлуудад туслах үйлсэд чиглүүлнэ.

Жефферсонын нэрэмжит сургууль олон нийтэд



Жефферсоны бүх сурагч үйлчилгээний сургалтад хамрагдах төлөвтэй байна. 6 болон 7-р ангийн сурагчид [сонирхлын чиглэлүүд](#)-ээс хоёрыг сонгох хэрэгтэй. Сурагчид чиглэл бүрийн үйлчилгээний цагийн сургалтад хамрагдах ёстой. Олон нийтийн цэцэрлэгт хүрээлэнд ажиллах, хандив өгөх, багшлах гэх мэт үйлчилгээний олон боломжуудыг Жефферсонд санал болгоно. [Үйлчилгээний сургалтын](#) талаар илүү ихийг эндээс Зураг: Хатагтай. Jenks.

Удахгүй болох арга хэмжээ, үйлчилгээний хуваарь

- Мягмар гараг бүр 17:00 цагт унадаг дугуй засахад сайн дураар туслах ажил Phoenix Bikes дэлгүүр дээр, 909 S. Dinwiddie St ([дэлгэрэнгүйг эндээс](#))
- Лхагва гараг бүр 18:30 цагт тахианы мах уутлахад сайн дураар туслах ажил AFAC дээр, 2708 S. Nelson St, ([дэлгэрэнгүйг эндээс](#))
- Хоолны автобусны талаарх асуудлаар [Ноён Malinosky-тай](#) холбогдоорой
- 8-р ангийнхан Олон нийтийн төслийг дуусгана